



2019 оны 01 дүгээр сарын 14
№02/1055/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Санхүүгийн хамтын
ажиллагааны хэлэлцээр
соёрхон батлах тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Дүрэмд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**Ялтан шилжүүлэх тухай
Монгол Улс, Бүгд Найрамдах
Казахстан Улс хоорондын гэрээ**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|----|--|----|
| 6. | Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр соёрхон батлах тухай | 21 |
| 7. | Гэрээ соёрхон батлах тухай | 22 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|----|---------------------------------------|------------|----|
| 8. | Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 161 | 22 |
|----|---------------------------------------|------------|----|

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

- | | | | |
|----|---|-----------|----|
| 9. | Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 03 | 23 |
|----|---|-----------|----|

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | | |
|-----|--|--|----|
| 10. | Санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн Газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газар хоорондын Хэлэлцээр | | 37 |
| 11. | Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ | | 41 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хооронд 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь-II төсөл”-ийн Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улс хооронд 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 12 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар
хот

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 302 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын төрийн шагналын тухай дүрэм”-ийн Гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “ардчилал, хүний эрхийн өдрийг” гэсний дараа “, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний болон цагаан сарын баярын өдрийг” гэж нэмсүгэй.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 302 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын төрийн шагналын тухай дүрэм”-ийн Нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “5 хүртэл” гэснийг “10 хүртэл” гэж, Хоёрдугаар зүйлийн 7 дахь хэсгийн “тухайн оны 11 дүгээр сарын 1-ний дотор” гэснийг “тухайн оны 11 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 1-ний дотор” гэж, Гуравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “5 сая” гэснийг “12 сая” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 302 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын төрийн шагналын тухай дүрэм”-ийн Гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгээс “Төрийн хүндэтгэлийн өргөөнд” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2018 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 11.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат /илтгэгч/, Д.Ганзориг, Ш.Цогтоо, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн ихсуудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Э.Эрдэнэцэцэг, Б.Оюу, А.Гулим болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” 76 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.



Нэг. Хэнтий аймгийн Баянхутаг сумын 2 дугаар багийн оршин суугч, иргэн С.Мөнхцэцэг Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий өргөдөл гаргасан байна. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтаар Хэнтий аймгийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийг 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс товлон зарлаж, санал авах өдрийг мөн оны 10 дугаар сарын 7-ны өдрөөр тогтоосон ба мөн тогтоолын 3 дахь заалтаар тогтоолын хэрэгжих хугацааг заасан байна.

Миний бие төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрхийн дагуу энэхүү нөхөн сонгуульд нэр дэвшихээр шийдээд байгаа юм. Нөхөн сонгуулийг Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “... энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.” гэж зохицуулсан байна.

Үндсэн хууль болон Сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 4 жил тутам явагдахаар цаг хугацааг нь тодорхой заасан бөгөөд иргэн хүн сонгуульд нэр дэвших эсэхээ эртнээс шийдэж, хуулиар тогтоосон шаардлагыг ханган оролцох боломжтой байдаг. Харин нөхөн сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 болон 137 дугаар зүйлийн 137.6 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн, гишүүнийг эгүүлэн татсан, гишүүн нас барсан тохиолдолд орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах бөгөөд нөхөн сонгууль явагдах эсэхийг урьдчилан тааж мэдэх ямар ч боломжгүй байдаг болно. Гэтэл энэ удаа нөхөн сонгууль зарлахад Сонгуулийн тухай хуульд нэгэнт товлон зарласан нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчдыг хэрхэн оролцуулах тухай зохицуулалт огт тусгагдаагүй хийдэл үүссэн байна.

Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал нь Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ эрх бүхий этгээдэд гаргасан байх ба сонгуулийн жилийн нэгдүгээр сарын 31-ээс хойш ажил, албан үүргээ гүйцэтгээгүй байна.”, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ... төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. ... Сонгуульд нэр дэвшихтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн

албанаас чөлөөлөхөд саад болохгүй.” гэж тус тус заасан. Дээрх хуулиудын зохицуулалтаас үзэхэд ээлжит сонгуульд нэр дэвших төрийн жинхэнэ албан хаагч нь “... сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ...”, “... тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ...” гэж төрийн албанаас чөлөөлөгдсөн байх хугацааг тодорхой заасан байна. Гэтэл нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчид хэзээ, хэрхэн ажлаасаа чөлөөлөгдөн оролцох зохицуулалтыг орхигдуулснаас төрийн байгууллагад ажиллаж буй төрийн жинхэнэ албан хаагчид нөхөн сонгуульд оролцохын тулд одоо ажлаасаа чөлөөлөгдөхөд дээр дурдсан хугацааны шаардлагыг хангаж чадахгүй тул сонгуульд оролцох боломжгүй болж байна. ...

Иймд төрөөс Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцох зохицуулалтыг тодорхой болгосны үндсэн дээр тус нөхөн сонгуулийг зарлах нь Үндсэн хуульд нийцэх бөгөөд улмаар төрийн жинхэнэ албан хаагчид Үндсэн хуулиар олгогдсон сонгогдох эрхээ эдлэх хууль зүйн баталгаа бүрдэх юм.

Ийнхүү төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа бүрдээгүй байхад нөхөн сонгууль болсон тохиолдолд нэр дэвших хүсэлт гаргасан боловч дээр дурдсан шаардлагыг хангаагүй үндэслэлээр сонгуульд оролцож чадаагүй төрийн албан хаагчид өргөдөл, мэдээлэл гаргасны улмаас нөхөн сонгууль бүхэлдээ хүчингүйд тооцогдож, дахин сонгууль болох улмаар үр дүнгүй их хэмжээний зардал гарч, улс орны эдийн засагт хохирол учруулах нөхцөл байдал бий болохыг үгүйсгэх аргагүй.

Энэ бүхний эцэст төрийн жинхэнэ албан хаагчид бид аливаа сонгууль болохоос өмнө хуулиар тогтоосон боломжит хугацаанд албан тушаалаасаа чөлөөлөгдөж, сонгуульд нэр дэвшиж, Үндсэн хуульд заасан сонгогдох эрхээ эдлэх хүсэлтэй байна. Тиймээс нөхөн сонгуульд төрийн албан хаагчид хэрхэн, яаж оролцохыг хуулиар тодорхой зохицуулсны дараа нөхөн сонгуулийг зарлах нь хууль дээдлэх ёс, эрх зүйт төрийн зарчим, үндсэн хуульт ёсонд нийцнэ. Үүний зэрэгцээ Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол дараах байдлаар Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна:

1. Төрийн албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцуулах хуулийн зохицуулалтыг орхигдуулж, хууль зүйн баталгаа хангах үүргээ төр биелүүлээгүй байхад нөхөн сонгууль зарласан нь төрийн жинхэнэ албан хаагчдыг нөхөн сонгуульд оролцох боломжгүй болгож, улмаар иргэн хүн сонгогдох эрхээ эдлэхэд тэгш бус шаардлага тавьж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал,



... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчиж байна.

2.Төрийн жинхэнэ албанд ажилласных нь төлөө иргэнд хуулиар биелүүлэх боломжгүй шаардлага тавьж, сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн суурь зарчмыг үгүйсгэж, улмаар хүнийг эрхэлж буй ажил, албан тушаалынх нь хувьд шууд ялгаварлан гадуурхсан гэж үзэхээр байгаа ба энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэж заасныг зөрчөөд байна.

3.Сонгуулийн тухай хуульд нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагч хэрхэн оролцох талаар зохицуулалтыг тодорхой тусгаагүй орхигдуулсан ба албан тушаалаасаа чөлөөлөгдөх хуулийн шаардлага нь нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлэх боломжгүй болгож, тэгш бус нөхцөлийг тулгаж, улмаар иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг ноцтойгоор зөрчиж байна. Түүнчлэн иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийн хууль зүйн баталгааг төрөөс бүрэн хангаагүй байхад нөхөн сонгуулийг товлон зарласан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчиж байна.

4.Улсын Их Хурлаас баталсан хууль нь Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрхийг бүрэн хангахад чиглэсэн баталгаа болохуйц байх ёстой. Хууль тогтоогчийн зүгээс Сонгуулийн тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй, зохицуулалтыг орхигдуулсан буюу төрийн жинхэнэ албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа хангагдаагүй байхад Улсын Их Хурлын 62 дугаар тогтоолоор нөхөн сонгуулийн тов зарлаж, санал авах өдрийг тогтоосон, мөн төрийн алба улс төрөөс ангид байх зарчмыг хэрэгжүүлэх зохицуулалт тодорхойгүй, ойлгомжгүй байгаа нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...” гэж заасан үүргээ зөрчсөн гэж үзэхээр байна.

5.Сонгуулийн тухай хуулиар нөхөн сонгуульд төрийн жинхэнэ албан хаагч оролцох эрхийн хууль зүйн баталгааг бүрэн хангаагүй атал Сонгуулийн ерөнхий хороо төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзах шийдвэр гаргах нөхцөл байдал үүсч, улмаар Үндсэн хуульд заасан хэзээ ч хязгаарлаж үл болох иргэний баталгаатай эдлэх улс төрийн эрхийг хязгаарлаж Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн шийдвэр болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж тус тус заасныг зөрчсөн байх тул хянан хэлэлцэж, дүгнэлт гаргаж өгнө үү." гээд өргөдлийн үндэслэлээ баталгаажуулан хавсарган ирүүлсэн баримтад:

Иргэн С.Мөнхцэцэгийн Сонгуулийн ерөнхий хороонд хандаж Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд (2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс товлон зарласан) нэрээ дэвшүүлэх хүсэлтэй төрийн албан хаагч эрхэлж буй ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хэзээ гаргаж, хэзээ чөлөөлөгдсөн байх шаардлагатай талаар тодруулга хүсэхэд, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албанаас 2018 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 66 дугаар албан бичгээр "Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсгийн зохицуулалтыг тусгаад Сонгуулийн төв байгууллагын хувьд хуулийг баримтлан ажиллах бөгөөд хууль тогтоомжийг тайлбарлах эрх хэмжээ тус байгууллагад олгогдоогүй тул тайлбар, тодруулга өгөх боломжгүй юм." гэсэн хариуг өгсөн байна.

Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 3 дугаар хороонд оршин суугч, иргэн Э.Эрдэнэцэцэг, Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороонд оршин суугч, иргэн Б.Оюу, Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд оршин суугч, иргэн А.Гулим нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл гаргасан байна. Үүнд:

"Улсын Их Хурлаас 2018 оны 62 дугаар тогтоол гарснаар төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирлын албан тушаал эрхэлж байгаа иргэд Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох боломжгүй болоод байна. Учир нь Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт дурдсан төрийн албан хаагчид Сонгуулийн тухай хуульд заасан нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлагаас гадна нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхийн тулд сонгуулийн жил буюу 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ өгч, 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш албан үүргээ гүйцэтгэхгүй байх нэмэлт шаардлага тавьсан нь одоо ажлаа



эрхэлж буй албан хаагч нь энэхүү шаардлагыг хангаагүй гэдэг үндэслэлээр нэр дэвшигчээр бүртгэхгүй байх улмаар Үндсэн хуульд заасан төрийн байгууллагад сонгогдох эрх зөрчигдөхөөр байна.

Нөхөн сонгууль нь Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн, гишүүнийг эгүүлэн татсан, гишүүн нас барсан тохиолдолд орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах бөгөөд Сонгуулийн тухай хуулиар дээр дурдсан албан хаагчийг нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгааг бүрдүүлээгүй байна. ... Ийнхүү дээр дурдсан төрийн албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа хангагдаагүй байхад Улсын Их Хурлаас 62 дугаар тогтоол гаргаж, нөхөн сонгуулийг зарлан иргэний төрийн байгууллагад сонгогдох эрх төрийн байгууллагын буруугаас зөрчигдөхөд хүргэж, улмаар төрийн албанд ажилласны төлөө нэрээ дэвшүүлэх эрхийг хязгаарлаж байгаа нь улс төрийн сонгуульд нэр дэвшигчид ижил тэнцүү нөхцөлд, шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх бус харин эсрэгээрээ Үндсэн хуулийн үндсэн зарчмыг үгүйсгэсэн Үндсэн хуулийн зөрчил юм.

Иймд Сонгуулийн тухай хуулиар дээр дурдсан төрийн албан хаагч нөхөн сонгуульд оролцох хууль зүйн баталгаа бүрэн хангагдаагүй байхад баталсан Улсын Их Хурлын 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтыг зөрчсөн, Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр болсон гэж үзэж байна.” гэжээ.

Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд оролцох Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн баталсан. Уг тогтоол нөхөн сонгуулийг эхлэх өдөр болон санал авах ажиллагааг явуулах өдрийг тогтоосон хоёр заалттай бөгөөд тухайн сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагын талаар тусгайлан зааж төрийн албан хаагчийн эрхийг хязгаарласан заалт уг тогтоолд байхгүй юм.

Иргэдийн өргөдөл, мэдээлэлд дурдсан Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт төрийн албан хаагч сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагыг заахдаа "... Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө ..." гэж заасан бөгөөд "сонгуулийн жил" гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. "Сонгуулийн жил" гэж мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад зааснаар дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгоно. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт зааснаар сонгууль нь ээлжит, ээлжит бус, нөхөн, дахин гэсэн төрлүүдтэй байх бөгөөд "Ээлжит сонгууль гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2, Гучдугаар зүйлийн 2, Тавин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт тус тус заасны дагуу дөрвөн жил тутам явагдах сонгуулийг хэлнэ." гэж заажээ. Одоо бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан дөрвөн жил тутам явагдах сонгуулийн үр дүнд байгуулагдсан бөгөөд 2016 онд явагдсан энэхүү сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасан ээлжит сонгууль юм. Харин Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт товлон зарласан сонгууль нь Сонгуулийн тухай хуулийн мөн зүйлийн 8.1.3 дахь заалтад заасан нөхөн сонгууль билээ. Эндээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасан "сонгуулийн жил" гэдэгт дөрвөн жил тутам явагдах ээлжит сонгуулийн жилийг ойлгох бөгөөд "сонгууль явуулах тухайн жил" гэсэн ойлголтыг агуулаагүй байгаа тул төрийн албанаас чөлөөлөгдөх шаардлагад заасан хугацаа нь Улсын Их Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшүүлэхэд хамаарахгүй юм.

Түүнчлэн Сонгуулийн тухай хууль батлагдсанаар хүчингүйд тооцогдсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт "Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна." гэж заасан нь одоогийн хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасантай хугацааны хувьд ижил шаардлага тавьж байсан бөгөөд уг заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэцээс өмнө нь хянан шийдвэрлэж 2015 оны 12 дугаар дүгнэлт болон мөн оны 10 дугаар тогтоолыг баталсан байна.

Үндсэн хуулийн цэцийн дээрх шийдвэрт "...Төрийн жинхэнэ буюу мэргэшсэн алба хаагчдыг ажил, мэргэжлийн онцлог, хэрэгжүүлэх чиг үүргийг харгалзан улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах, төвийг сахисан байр суурийг хадгалахад чиглэсэн тусгай шаардлага, шалгуурыг тэдэнд тавьж холбогдох хуулиар зохицуулах нь хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал юм. ... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн



26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... шударга ёс, ... үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ..." гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна." гэж дурдсанаас үзэхэд сонгуульд нэр дэвших төрийн албан хаагчийн төрийн албанаас чөлөөлөгдөх хугацааны шаардлагыг Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад "Улсын Их Хурал ... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ." гэж, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана." гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт "Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана." гэж, мөн хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана." гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2018 оны 62 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд төрийн албан хаагчдын сонгуульд нэр дэвших харилцаатай холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай" 62 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчөөгүй болно." гэсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаараа энэхүү маргааныг хянан хэлэлцээд 10 дугаар дүгнэлтийг гаргасан байна. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

"1. Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан өөрийн бүрэн эрхийн хүрээнд 62 дугаар тогтоол батлан гаргаж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль товлон зарлаж, санал авах өдрийг тогтоосон байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” хэмээн Монгол Улсын иргэн төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хуралд сонгогдох эрхтэй болохыг нийтлэг байдлаар хуульчилсан байна. Мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хүлээхээр зааж, Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.” гэжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын дагуу Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийг баталж, тус хуулиар Монгол Улсын Их Хурлын болон бусад байгууллагын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах хэм хэмжээг тогтоожээ.

Сонгуулийн тухай энэхүү хуулиар Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан иргэдийн өргөдөл, мэдээлэлд дурдсан нөхцөл байдал буюу нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд тухайн сонгуульд нэр дэвших, улмаар төрийн байгууллагад сонгогдох эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг хууль тогтоогч бүрэн бүрдүүлээгүй гэж үзэхээр байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан дөрвөн жил тутам явагдах Улсын Их Хурлын ээлжит сонгуульд төрийн албанд ажиллаж буй иргэд нэрээ дэвшүүлэх, эсхүл нэр дэвших тохиолдолд Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсэгт заасан хугацааны дотор ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргахыг тодорхой заажээ. Харин Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэхийг хүссэн төрийн албанд ажиллаж байгаа иргэд тухайн сонгуулийн санал хураалт болох өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргах, чөлөөлөгдсөн байх талаарх зохицуулалтыг Сонгуулийн тухай хуульд тусгаагүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлд Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх талаарх нийтлэг зохицуулалтыг хуульчлахдаа тус зүйлийн 128.2.7, 128.3.6 дахь заалтад “төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх тухай хүсэлт, ажил албан тушаалаас чөлөөлөх тухай шийдвэрийн тус тус нотариатаар батлуулсан хуулбар;” зэргийг нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан сонгуулийн төв байгууллагад ирүүлэхээр заасан байна. Түүнчлэн тус хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1.2 дахь заалтад “нэр



дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;”, 129.1.5 дахь заалтад “нэр дэвшигчийг бүртгүүлэхэд шаардагдах энэ хуульд заасан баримт бичиг дутуу ...;” зэрэг шаардлагыг хангаагүй бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзахаар зохицуулжээ.

Үүнээс үзэхэд Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.2.7, 128.3.6 дахь заалтад хамаарах иргэдийн хувьд нөхөн сонгуульд санал авах өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байх зохицуулалтыг хуульд тусгаагүйн улмаас энэ шаардлагыг урьдчилан хангах хууль зүйн боломж бүрдээгүй байна. Ингэснээр иргэд уг сонгуульд нэрээ дэвшүүлж чадахгүйд хүрч, улмаар тэдний хувьд тэгш бус байдал буюу эрхэлсэн ажил, албан тушаалаасаа хамааран ялгаварлагдах хууль зүйн үндэслэл бий болохын хамт нөхөн сонгуульд оролцож сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүй нөхцөл байдал үүсжээ. Иймд сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тулгамдсан асуудал байгааг дурдах нь зүйтэй юм.

3. Хууль тогтоогч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах шийдвэрийг гаргахдаа Үндсэн хуульт ёс, ардчилсан эрх зүйт төрийн суурь үзэл баримтлал, иргэний улс төрийн эрхийн хязгаарлалтын талаарх нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл зарчимд нийцүүлэн Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу тухайн сонгуульд оролцох иргэдийн эрх зүйн байдлыг тогтоох ёстой атал иргэдэд тэгш бус байдлыг бий болгосон сонгуулийн хууль тогтоомжийн хийдлийг арилгахгүйгээр 2018 оны 62 дугаар тогтоолыг баталжээ.

Уг тогтоолыг болон Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн зардлыг хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, түүнчлэн чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцахад холбогдох хуралдаан дээр нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд төрийн албанд ажиллаж буй иргэдийн сонгогдох эрх хязгаарлагдаж, тэгш бус байдал үүсэх эрх зүйн нөхцөл бүрдэж байгаа талаар яригдаж байсан нь нотлогдож байна.

Иймд Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчиж, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш

байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэж заасан нь зөрчигдөх нөхцөл бүрдсэн байна.” гэжээ.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт

“1. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.” гэжээ.

Тав. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” 76 дугаар тогтоолд:

“Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал өгөх өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно.



...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.

Зургаа. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд оролцох Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг дараах үндэслэлээр хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн баталсан. Уг тогтоол нөхөн сонгуулийг эхлэх өдөр болон санал авах ажиллагааг явуулах өдрийг тогтоосон хоёр заалттай бөгөөд тухайн сонгуульд нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлагын талаар тусгайлан зааж төрийн албан хаагчийн эрхийг хязгаарласан заалт уг тогтоолд байхгүй юм.

... Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “Улсын Их Хурал ... Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гэж, Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана.” гэж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургадугаар сарын сүүлийн Ням гараг болон аравдугаар сарын эхний Ням гараг байх ба улс даяар нэгдсэн журмаар явагдана.” гэж, мөн хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол нөхөн сонгууль явагдана.” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд 2018 оны 62 дугаар тогтоолыг баталж, нөхөн сонгуулийг товлон зарласан бөгөөд уг тогтоолд төрийн албан хаагчдын сонгуульд нэр дэвших харилцаатай холбоотой аливаа зохицуулалт байхгүй болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус зөрчөөгүй болно.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Сонгуулийн тухай хуульд төрийн албанд ажиллаж буй иргэн Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нэрээ дэвшүүлэх, эсхүл нэр дэвших тохиолдолд хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан байх шаардлагыг тодорхой заасан боловч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгууль зарлагдсан тохиолдолд тухайн сонгуулийн санал хураалт болох өдрөөс хэдий хугацааны өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ гаргах, чөлөөлөгдсөн байх талаарх зохицуулалтыг тусгаагүй байна. Үүний улмаас төрийн албанд ажиллаж буй иргэд Сонгуулийн тухай хуульд заасан шаардлагыг урьдчилан хангаж Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд нэрээ дэвшүүлэх боломжгүй болж, эрхэлсэн ажил, албан тушаалаасаа хамааран сонгогдох эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрчээ.

2. Хууль тогтоогч Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох шийдвэрийг хэлэлцэж байх үед дээр дурдсан нөхцөл байдал үүссэн нь тодорхой байсан атал иргэдэд тэгш бус байдлыг бий болгосон сонгуулийн хууль тогтоомжийн хийдлийг арилгахгүйгээр 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр 62 дугаар тогтоол гаргажээ. Тодруулбал, уг тогтоолыг болон Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн зардлыг хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс үзэхэд нөхөн сонгууль товлон зарлагдсан тохиолдолд төрийн албанд ажиллаж буй иргэдийн сонгогдох эрх хязгаарлагдаж, тэгш бус байдал үүсэх эрх зүйн нөхцөл бүрдэж байгаа талаар яригдаж байсан байна. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, сонгогч, сонгогдогч иргэдийн эрхийг тэгш хангаж холбогдох заалтуудыг өөрчлөх эрх нь хууль тогтоогчид байгаа юм.

Үүнээс үзэхэд, Монгол Улсын Их Хурал 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал өгөх өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол батлан гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр



зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасан заалт зөрчигдөх нөхцөл бүрдсэн байна хэмээн үзсэн Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

3. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 76 дугаар тогтоолд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн хэдий ч ийнхүү хүлээн зөвшөөрөхгүй гэж үзсэн хууль зүйн үндэслэлээ тодорхой тайлбарлаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” 76 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Д.ОДБАЯР

ГИШҮҮД

**Н.ЧИНБАТ
Д.ГАНЗОРИГ
Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Ц.НАНЗАДДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

2016-2017 он

Биологийн олон янз байдлыг хамгаалах,
уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II

Монгол Улсын Засгийн Газар,
Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газар-

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд тогтсон найрсаг харилцааны үзэл санаанд тулгуурлан,

энэхүү найрсаг харилцааг түншилсэн Санхүүгийн хамтын ажиллагаагаар бэхжүүлэн, гүнзгийрүүлэхийг эрмэлзэж,

уг харилцааг хэвээр хадгалах нь энэхүү Хэлэлцээрийн үндсийг бүрдүүлнэ гэдгийг ухамсарлан, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд байгаль орчны тогтвортой байдалд тулгуурлан хувь нэмэр оруулах зорилгоор,

хоёр орны Засгийн газар хоорондын 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хэлэлцээний протокол, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас суугаа Элчин сайдын яамнаас мэдэгдсэн амлалтуудыг (2016 оны 12 дугаар



сарын 8-ны өдрийн 182/2016 тоот төлөөний ноот, 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 163/2017 тоот төлөөний ноот) үндэслэн -

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов.

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

(1) Хэрэв дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж судалгааны дүнд тогтоож, эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг бэхжүүлэх болон ядууралтай тэмцэхэд өөрөө өөртөө туслахад чиглэсэн арга хэмжээ, эсхүл дунд хэмжээний үйлдвэрт зээлийн баталгаа гаргах сан, байгаль орчныг хамгаалах болон нийгмийн дэд бүтцийн төсөл болохын хувьд санхүүгийн тусламж олгон дэмжих онцгой нөхцөлийг хангаж буйг нь нотолсон бол Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газар нь Монгол Улсын Засгийн Газарт “Биологийн олон янз байдлыг хамгаалах ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь II” төсөлд

а) 13 500 000 (үсгээр: арван гурван сая таван зуун мянга) хүртэлх еврогийн 2016 оны санхүүгийн хөрөнгийг;

б) 6 000 000 (үсгээр: зургаан сая) хүртэлх еврогийн 2017 оны санхүүгийн хөрөнгийг

Сэргээн босголтын зээлийн банк (KfW)-наас авах боломж олгоно.

(2) Монгол Улсын Засгийн Газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газар хооронд харилцан тохиролцооноор 1 дүгээр заалтад дурдсан төслийг өөр төслүүдээр орлуулж болно. 1 дүгээр заалтад дурдсан төслийг байгаль орчныг хамгаалах буюу нийгмийн дэд бүтцийн төсөл, эсхүл дунд хэмжээний үйлдвэрт зээлийн баталгаа гаргах сан, эсхүл эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг сайжруулах, ядууралтай тэмцэх өөрөө өөртөө туслахад чиглэсэн арга хэмжээ болохын хувьд санхүүгийн хөрөнгө олгох замаар дэмжих онцгой нөхцөлийг хангаж буй өөр төслөөр орлуулбал санхүүгийн хөрөнгө олгож болно. 1 дүгээр заалтын б) -д дурдсан хөрөнгө нь үүнд хамаарахгүй болно.

(3) Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газар нь 1 дүгээр заалтад дурдсан төслийн бэлтгэл ажлыг хангахад зориулан нэмэлт зээл эсвэл санхүүгийн хөрөнгө, эсхүл 1 дүгээр заалтад дурдсан төслийг хэрэгжүүлэх, дэмжихэд шаардагдах дагалдах арга хэмжээнд зориулан нэмэлт санхүүгийн хөрөнгө Сэргээн босголтын зээлийн банкнаас авах



боломжийг Монгол Улсын Засгийн газарт хожим олгох тохиолдолд энэхүү Хэлэлцээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

2 ДУГААР ЗҮЙЛ

(1) Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтад дурдсан хөрөнгийг ашиглах, түүнийг олгох нөхцөл болон ажил гүйцэтгүүлэх журмыг Сэргээн босголтын зээлийн банк, санхүүгийн хөрөнгө хүлээн авагчийн хооронд байгуулах, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хууль тогтоомжийг мөрдлөг болгох гэрээгээр зохицуулна.

(2) Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтын а) -д дурдсан хөрөнгийг олгох амлалт өгснөөс хойш зургаан жилийн дотор холбогдох санхүүжилтийн гэрээнүүд байгуулагдаагүй тохиолдолд уг амлалт хүчингүй болно. Дээрх заалтад дурдсан хөрөнгийн хувьд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр уг хугацаа дуусгавар болно.

(3) Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтын б) -д дурдсан хөрөнгийг олгох амлалт өгснөөс хойш хоёр жилийн дотор холбогдох санхүүжилтийн гэрээнүүд байгуулагдаагүй тохиолдолд уг амлалт хүчингүй болно. Дээрх заалтад дурдсан хөрөнгийн хувьд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр уг хугацаа дуусгавар болно.

(4) Монгол Улсын Засгийн Газар нь санхүүгийн хөрөнгө хүлээн авагч биш байх тохиолдолд 1 дүгээр заалтын дагуу байгуулах санхүүжилтийн гэрээгээр үүсч болох аливаа төлбөрийг эргэн төлөх баталгааг Сэргээн босголтын зээлийн банканд гаргана.

3 ДУГААР ЗҮЙЛ

Монгол Улсын Засгийн Газар нь энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад дурдсан гэрээнүүдийг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдон ноогдуулж болох Монгол Улсын шууд татвар, хураамжаас Сэргээн босголтын зээлийн банкиг чөлөөлнө. Дээр дурдсантай холбогдуулан ноогдуулсан нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад адил төрлийн шууд бус татвар, ноогдуулсан онцгой албан татварыг Монгол Улсын Засгийн Газар хариуцна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн Газар нь бусад албан татвар, хураамжаас Сэргээн босголтын зээлийн банкиг чөлөөлнө.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Монгол Улсын Засгийн Газар нь санхүүгийн хөрөнгө олгосонтой холбоотойгоор зорчигч болон ханган нийлүүлэгчдийг хуурай болон усан зам, агаараар хүн болон бараа тээвэрлэх тээврийн байгууллагыг чөлөөтэй сонгох боломжоор ханган, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад



байрладаг тээврийн байгууллагуудыг үүнд тэгш эрхтэй оролцоход саад тотгор болох, эсхүл хязгаарлах аливаа арга хэмжээг авахаас түдгэлзэн, шаардлагатай нөхцөлд тэдэнд зохих зөвшөөрлийг олгоно.

5 ДУГААР ЗҮЙЛ

(1) Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухай мэдэгдлийг Монгол Улсын Засгийн Газраас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газарт хүргүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох өдөр нь дээрх мэдэгдлийг хүлээн авсан өдөр байна.

(2) Энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болмогц Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлнэ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газар бүртгэж авснаа баталгаажуулмагц хэлэлцэн тохиролцогч нөгөө Талд Хэлэлцээрийг бүртгүүлсэн тухай НҮБ-ын бүртгэлийн дугаарыг заан мэдээлнэ.

(3) Энэхүү Хэлэлцээрийг хугацаагүй байгуулсан болно. Хэлэлцэн тохиролцогч Талууд Хэлэлцээрийг дипломат шугамаар хэдийд ч цуцлах боломжтой бөгөөд Хэлэлцээр нь Хэлэлцээрийг цуцлах тухай хүсэлтийг хэлэлцэн тохирогч нөгөө Тал хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дараа цуцлагдана.

(4) Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тохиролцож болно.

(5) Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхэд үүсэх маргааныг хэлэлцэн тохиролцогч Талууд яриа, хэлэлцээний замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

Энэхүү Хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр монгол, герман, англи хэл дээр тус бүр хоёр эх хувь байгуулсан бөгөөд эх хувь бүр нь адил хүчинтэй байна. Герман, монгол хэл дээрх эх бичвэрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

Монгол Улсын
Засгийн Газрыг төлөөлж

Холбооны Бүгд Найрамдах
Герман Улсын Засгийн Газрыг төлөөлж

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ

Монгол Улс ба Бүгд Найрамдах Казахстан Улс нь /цаашид “талууд” гэх/ бүрэн эрхт байдал болон эрх тэгш байхыг харилцан хүндэтгэх үндсэн дээр,

хоёр улсын хоорондын эрүүгийн эрх зүйн харилцаанд эрх зүйн хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэн,

ялыг ялтны харьяалагдах улсад эдлүүлэх нь түүний нийгэмшихэд дэм болохыг харгалзан,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов.

1 дүгээр зүйл **Тодорхойлолт**

Энэхүү гэрээний зорилгоор дараахь тодорхойлолтыг хэрэглэнэ:

а) “шилжүүлэгч тал” гэж ялтныг өөрийн нутаг дэвсгэрээс шилжүүлж буй эсхүл шилжүүлсэн талыг;

б) “хүлээн авагч тал” гэж ялтныг өөрийн нутаг дэвсгэр дээр хүлээн авч буй эсхүл хүлээн авсан талыг;

в) “ялтан” гэж шилжүүлэгч талын шүүхээс оноосон хугацаагаар хорих ял эдэлж буй этгээдийг тус тус ойлгоно.

2 дугаар зүйл **Нийтлэг үндэслэл**

Аль ч тал ялтныг шилжүүлэгч талын шүүхээс оногдуулсан ялыг эдлүүлэхээр нөгөө талд энэхүү гэрээнд заасны дагуу шилжүүлэх эрхтэй.

3 дугаар зүйл **Төв байгууллага**

1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ талууд өөрсдийн томилсон төв байгууллагаар дамжуулан харилцана.



2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан төв байгууллага нь Монгол Улсын хувьд Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд Ерөнхий прокурорын газар байна.

3. Аль нэг тал дурдсан төв байгууллагаа өөрчилсөн тохиолдолд энэ тухайгаа дипломат шугамаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

4 дүгээр зүйл

Шилжүүлэх нөхцөл

1. Ялтныг дараахь нөхцөлд шилжүүлж болно. Үүнд:

а) ялтан нь хүлээн авагч талын иргэн байх;

б) ялтанд ял оногдуулсан үйлдэл, эс үйлдэхүй нь хүлээн авагч талын хууль тогтоомжоор мөн адил гэмт хэрэгт тооцогддог байх;

в) шилжүүлэх тухай хүсэлт хүлээн авах үед шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бөгөөд ялтны ял эдлэх үлдсэн хугацаа нэгээс доошгүй жил байх;

г) шилжүүлэхийг ялтан өөрөө эсхүл ялтны нас, эрүүл мэнд болон сэтгэцийн байдлаас шалтгаалан бие даан өөрийн хүсэл зоригоо илэрхийлэх боломжгүй тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгч бичгээр зөвшөөрсөн байх;

д) талууд ялтныг шилжүүлэхийг харилцан зөвшөөрсөн байх.

2. Онцгой тохиолдолд, ялтны эдлээгүй үлдсэн ялын хугацаа нь энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн “в” заалтад зааснаас бага байсан ч талууд тухайн ялтныг шилжүүлэхийг зөвшөөрч болно.

5 дугаар зүйл

Шилжүүлэхээс татгалзах

1. Ялтныг дараахь нөхцөлд шилжүүлэхээс татгалзаж болно. Үүнд:

а) Аль нэг тал ялтныг шилжүүлэх нь тухайн улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулах буюу үндэсний хууль тогтоомж дахь суурь зарчимд нийцэхгүй гэж үзвэл;

б) ялтан шилжүүлэгч талын нутаг дэвсгэрт иргэний нэхэмжлэлд хариуцагчаар тогтоогдсон бол.

2. Аль ч тал энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлөөс үл хамааран нөгөө талын хүсэлтээр ялтныг шилжүүлэх эсэхийг өөрийн үзэмжээр шийдвэрлэж болно.

6 дугаар зүйл
Хүсэлт гаргах ба хариу өгөх

1. Ялтан эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь энэхүү гэрээнд заасны дагуу шилжих асуудлаар аль ч талд хандаж болно. Ялтан аль нэг талд шилжих асуудлаар хандахад тухайн тал энэ тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

2. Ялтан шилжүүлэх хүсэлтийг аль ч талд гаргаж болно. Хүсэлт хүлээн авсан тал нь шилжүүлэхийг зөвшөөрөх эсэх талаар гаргасан шийдвэрээ хүсэлт гаргасан талд шуурхай мэдэгдэнэ.

3. Шилжүүлэх тухай хүсэлт болон хариуг бичгээр үйлдэх бөгөөд энэхүү гэрээний 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шугамаар илгээнэ.

7 дугаар зүйл
Бичиг баримтаар хангах

1. Шилжүүлэх хүсэлт гаргасан үед хүсэлт хүлээн авсан тал татгалзаагүй бол шилжүүлэгч тал дараах баримт бичиг болон мэдээллийг хүлээн авагч талд хүргүүлнэ. Үүнд:

а) шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоол болон түүнийг гаргахад үндэслэл болсон хуулийн холбогдох заалтын баталгаажуулсан хуулбар;

б) ялын төрөл, хугацаа болон хугацааг тоолж эхэлсэн огнооны тухай мэдээлэл;

в) ялтны ял эдлэх дэглэм, эдэлсэн болон үлдсэн ялын хугацаа, урьдчилан хоригдсон хугацаа, шийтгэх тогтоолд өөрчлөлт орсон эсэх талаар болон шийтгэх тогтоолыг гүйцэтгэхэд хамааралтай бусад мэдээлэл;

г) энэхүү гэрээний 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “г” заалтад заасан бичгээр гаргасан шилжүүлэх зөвшөөрөл;

д) ялтны биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл.



2. Хүлээн авагч тал нь шилжүүлэгч талд дараах баримт бичиг, мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:

а) ялтан нь хүлээн авагч талын иргэн болохыг нотолсон баримт бичиг эсхүл мэдээлэл;

б) ялтны ял шийтгүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйд хүлээн авагч улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэдгийг нотолсон хуулийн заалт;

в) Шилжүүлэгч талын шийтгэх тогтоолыг хүлээн авагч талын үндэсний хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх журмын тухай мэдээлэл.

8 дугаар зүйл

Ялтанд мэдэгдэх

1. Талууд өөрсдийн нутагт дэвсгэрт ял эдэлж байгаа бөгөөд энэхүү гэрээний үйлчлэлд хамаарах этгээдэд гэрээний дагуу шилжих боломжтойг мэдэгдэнэ.

2. Талууд өөрсдийн нутаг дэвсгэрт ял шийтгүүлсэн этгээдэд энэхүү гэрээний 6 дугаар зүйлийн дагуу шилжүүлэх тухай хүсэлттэй холбогдуулан шилжүүлэгч болон хүлээн авагч талаас гаргасан аливаа шийдвэрийн талаар бичгээр мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл

Ялтны зөвшөөрөл ба нотолгоо

1. Хүлээн авагч тал ялтан эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь ялтан шилжүүлснээр үүсэх эрх зүйн үр дагаврыг бүрэн ухамсарлан, шилжүүлэхийг сайн дураар зөвшөөрч, ийнхүү зөвшөөрснөө зөвшөөрөл өгөх замаар баталгаажуулсан эсэхийг мэдэх эрхтэй.

2. Хүлээн авагч тал хүсэлт гаргасан тохиолдолд шилжүүлэгч тал хүлээн авагч талыг ялтан шилжих зөвшөөрлөө энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагын дагуу өгсөн эсэхийг өөрийн бүрэн эрхт төлөөлөгчөөрөө дамжуулан баталгаажуулах боломжоор хангана.

10 дугаар зүйл

Ялтныг шилжүүлэх

Ялтныг шилжүүлэхээр тохиролцолд хүрсэн бол талууд энэхүү гэрээний 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шугамаар дамжуулан зөвлөлдөж шилжүүлэх цаг, газар, журмыг харилцан тогтооно.



11 дүгээр зүйл

Шийтгэх тогтоолыг гүйцэтгэх

1. Хүлээн авагч тал нь ялтныг шилжүүлж авсны дараа шилжүүлэгч талын оногдуулсан ялыг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу үргэлжлүүлэн эдлүүлнэ.

2. Шилжүүлэгч талын оногдуулсан ялын дэглэм, хугацаа нь хүлээн авагч талын хууль тогтоомжтой нийцэхгүй бол хүлээн авагч тал нь өөрийн улсын хуульд заасан ижил төрлийн гэмт хэрэгт оногдуулдаг ялын хэмжээтэй нийцүүлэн тухайн ялыг өөрчилж болно. Энэ тохиолдолд:

а) Хүлээн авагч тал нь шийтгэх тогтоолд дурдсан баримт сэлтийг хүлээн зөвшөөрнө;

б) Хүлээн авагч тал нь хорих ялыг торгох ялаар өөрчлөх эрхгүй;

в) Хүлээн авагч тал шийтгэх тогтоолыг өөрчлөхдөө шилжүүлэгч талын шийтгэх тогтоолын мөн чанартай аль болох нийцүүлсэн байх ёстой;

г) Хүлээн авагч тал шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулахдаа ялыг хүндрүүлэх ёсгүй бөгөөд өөрийн үндэсний хууль тогтоомжид заасан ижил төрлийн гэмт хэрэгт оногдуулдаг ялын дээд хэмжээнээс хэтрүүлэх ёсгүй;

д) Өөрчилсөн ял нь хүлээн авагч талын үндэсний хууль тогтоомжид заасан ижил төрлийн гэмт хэрэгт оногдуулдаг ялын доод хэмжээгээр хязгаарлагдах ёсгүй;

е) Шилжүүлэгч талын нутаг дэвсгэрт ялтны эдэлсэн хорих ялын хугацааг хасаж тооцно.

3. Ялтныг шилжүүлсний дараа ялыг эдлүүлэх, ялыг хөнгөрүүлэх болон хугацаанаас өмнө суллах асуудлыг хүлээн авагч талын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл

Шүүн таслах эрх хадгалагдах

1. Шилжүүлэгч тал өөрийн шийтгэх тогтоолыг өөрчлөх эсхүл хүчингүй болгох эрхтэй.

2. Энэхүү зүйлд заасны дагуу шилжүүлэгч тал ялыг өөрчилсөн эсхүл хүчингүй болгосон бол хүлээн авагч тал шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг өөрчлөх буюу хүчингүй болгоно.



13 дугаар зүйл
Уучлал, өршөөл үзүүлэх

Талууд нь өөрсдийн үндэсний хууль тогтоомжийн дагуу ялтанд уучлал, өршөөл үзүүлэх эрхтэй ба энэ тухай нөгөө талдаа нэн даруй энэхүү гэрээний 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шугамаар мэдэгдэнэ.

14 дүгээр зүйл
Шийтгэх тогтоолын гүйцэтгэлийн талаар мэдээлэх

Хүлээн авагч тал нь дараах нөхцөлд шилжүүлэгч талыг шийтгэх тогтоолын гүйцэтгэлийн талаарх мэдээллээр хангана. Үүнд:

- а) ял эдэлж дууссан;
- б) ялтан ялаа эдэлж дуусаагүй байхдаа хорих байгууллагаас оргон зайлсан эсхүл нас барсан;
- в) шилжүүлэгч тал тусгай мэдээлэл хүссэн бол.

15 дугаар зүйл
Дамжин өнгөрүүлэх

1. Аль нэг тал нь гуравдагч улстай хамтран нөгөө талын нутаг дэвсгэр дээгүүр ялтныг дамжин өнгөрүүлэх бол тухайн талаас дамжин өнгөрөх зөвшөөрөл авна.

2. Ялтныг агаарын тээврийн хэрэгсэл ашиглан дамжин өнгөрүүлэх бөгөөд нөгөө талын нутаг дэвсгэр дээр газардуулахаар төлөвлөөгүй тохиолдолд энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрөл авах шаардлагагүй.

3. Дамжин өнгөрөх хүсэлт гаргасан талын хүсэлтийг хүсэлт хүлээн авсан тал үндэсний хууль тогтоомжид нь харшлаагүй тохиолдолд хангах ёстой.

16 дугаар зүйл
Харилцах хэл

Талуудын төв байгууллага нь энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ орос хэлээр харилцана. Ингэхдээ аль нэг талын албан ёсны хэл дээрх баримт бичгийг нөгөө талын албан ёсны хэл рүү эсхүл орос хэл рүү орчуулсан байна.

17 дугаар зүйл

Баримт бичгийн баталгаажуулалт

Энэхүү гэрээний хүрээнд талуудын төв байгууллагын бэлтгэсэн болон энэхүү гэрээний 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шугамаар илгээсэн баримт бичгийг талуудын эрх бүхий байгууллага гарын үсэг, тамгаар баталгаажуулах бөгөөд ийм баримт бичгийг нөгөө талын нутаг дэвсгэр дээр дахин баталгаажуулалт хийлгэх болон хууль ёсны гэрчилгээ хийлгэлгүй ашиглаж болно.

18 дугаар зүйл

Зардал

1. Хүлээн авагч тал дараахь зардлыг хариуцна. Үүнд:

а) ялтныг шилжүүлэхтэй холбоотой шилжүүлэгч талын нутаг дэвсгэр дээр гарсан зардлаас бусад зардал;

б) ялтныг шилжүүлсний дараа шийтгэх тогтоолыг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардал.

2. Хүлээн авагч тал нь ялтнаас ялтан шилжүүлэхтэй холбогдон гарсан зардлыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн төлөхийг шаардах эрхтэй.

19 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

Энэхүү гэрээг тайлбарлах болон хэрэглэхтэй холбогдон гарах аливаа маргаанаар талуудын төв байгууллагууд хоорондоо тохиролцолд хүрч чадаагүй тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

20 дугаар зүйл

Нэмэлт, өөрчлөлт оруулах

Энэхүү гэрээнд хоёр талын харилцан зөвшилцсөнөөр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний 21 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан журмын дагуу тус гэрээний салшгүй хэсэг болох тусдаа протокол үйлдэж баталгаажуулна.

21 дүгээр зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох ба цуцлах

1. Энэхүү гэрээг соёрхон батлах бөгөөд соёрхон баталсан тухай Батламж жуух бичгийг солилцсон өдрөөс эхлэн гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Аль ч тал хэдийд ч дипломат шугамаар дамжуулан нөгөө талдаа бичгээр мэдэгдсэний үндсэн дээр энэхүү гэрээг цуцлах эрхтэй. Энэ тохиолдолд энэхүү гэрээ гэрээг цуцлах тухай мэдэгдлийг хүлээж авсан өдрөөс эхлэн зуун наяд (180) хоногийн дараа цуцлагдана. Энэхүү гэрээний үйлчлэл зогссоноос хойш түүнийг үйлчилж байх хугацаанд эхлүүлсэн ялтан шилжүүлэх ажиллагаа хэрэгжиж дуустал хүчинтэй байна.

3. Энэхүү гэрээ тус гэрээг хүчин төгөлдөр болохоос өмнө ял шийтгүүлсэн ялтныг шилжүүлэхэд үйлчилнэ.

Дээр дурдсаныг нотолж, талуудын Засгийн газраас бүрэн эрх олгогдсоны үндсэн дээр энэхүү гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү гэрээг 2018 оны 3 сарын 29-ний өдөр, Астана хотноо монгол, казах, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр бүр адил хүчинтэй байна. Гэрээг тайлбарлахад зөрүү гарвал орос хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

**ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ
ЭЛЧИН САЙД
ЛУВСАНГИЙН БАТТУЛГА**

**БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ЕРӨНХИЙ ПРОКУРОР
КАЙРАТ ПЕРНЕСОВИЧ
КОЖАМЖАРОВ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn
Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003